



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар A/299

Мөрөн сум

Шугам сүлжээний ажлыг хүлээж авах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн “Мөрөн сумын 1-р багт хийгдсэн цэвэр, бохир усны шугам сүлжээний” ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссны дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга,
хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Т.Бат-Эрдэнэ (Барилгын хөгжлийн төвийн ББЗХХ-н хяналтын инженер)

М.Анхбаяр (Барилгын хөгжлийн төвийн ББЗХХ-н хяналтын инженер)

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн,
Ерөнхий архитектор)

Д.Аюушжав (Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын
байцаагч)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн Архивын тасгийн дарга)

Ж.Нацагдорж (Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын
улсын байцаагч, Хошууч)

Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын ЗДТГазрын Архитектор, дэд бүтэц нийтийн
тээвэр хариуцсан мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

П.Халиунаа (“Урбан Девелопмент Консалтинг Групп ХХК-ийн инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Д.Хатанбаатар (“Ноён Өндөр” ХХК-ийн Захирал)

Х.Ренчинцогт (“Ноён Өндөр” ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

П.Лхагважав (“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн Захирал)

Д.Сүхээ (“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн ерөнхий инженер)

Комиссын нарийн бичгийн дарга:

Д.Нямбат (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилгын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 09 дүгээр сарын 31-ний өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилгын ажлыг хүлээж авахтай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат)-д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга, байгууламжийн ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Шугам сүлжээ, барилга байгууламжийг хүлээн авсан тухай мэдээллийг олон нийтэд сурталчилж, мэдээ мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

6. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН